



### ЭМ НАЙРУУЛАГЧ

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Дангаар болон бусадтай хамтран өгүүлэл, илтгэл хэлэлцүүлж хэвлүүлсэн байх;
2. Ажиллах хугацаандаа 2-оос доошгүй мэргэжигчийг дагалдуулан сургаж, дадлагажуулсан байх;
3. Ард иргэдэд эмийн зохистой хэрэглээний талаар сургалт, сурталчилгаа явуулахад оролцсон байх;
4. Мэргэжлийн чиглэлээр зохион байгуулагдсан хурал, семинарт оролцсон байх;
5. Мэргэжлийн холбооны үйл ажиллагаанд идэвх санаачлагатай оролцдог байх.

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Дангаар болон бусадтай хамтран 3-аас доошгүй өгүүлэл, илтгэл хэлэлцүүлж хэвлүүлсэн байх;
2. Ажиллах хугацаандаа 3-аас доошгүй мэргэжигчийг дагалдуулан сургаж, дадлагажуулсан байх;
3. Шинэлэг арга технологи санаачилж, эзэмшиж үр дүнд хүрэхэд оролцсон байх;
4. Ард иргэдэд эмийн зохистой хэрэглээний талаар сургалт, сурталчилгаа явуулсан байх;
5. Мэргэжлийн чиглэлээр зохион байгуулагдсан хурал, семинарт оролцсон байх;
6. Мэргэжлийн холбооны үйл ажиллагаанд идэвх санаачлагатай оролцдог байх.